

ЗҮҮН АЗИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН ТУХАЙД (Эрэгцүүлэл)

С.Дашцэвэл*

Товч утга:

Зүүн Азийн хамтын ажиллагааны эхлэл, өнөөгийн явц. Зүүн Азийн хамтын ажиллагаанд оролцох Монгол улсын хүсэл эрмэлзлэл. Түүнд тохиолдож буй бэрхшээл. Түүнийг гэтлэн давах тухай эрэгцүүлэл.

Түлхүүр үг: ASEAN, Зүүн Өмнөд Ази, чөлөөт худалдааны бүс, Зүүн Азийн дээд уулзалт

Хүйтэн дайн төгсгөл болсны дараа Зүүн Азийн улс орнуудын хоёр талын хамтын ажиллагаа урьд урьдахаас илүү идэвхжиж тэр нь улмаар олон талт хамтын ажиллагаа болон өргөжих замд оров. Зүүн Азийг хамарсан олон талт хамтын ажиллагаа, регионализмын үзэл санаа үндсэндээ 90-ээд оны дунд үеэс эхэлсэн байна. Энэ нь дараах нөхцөл шалтгаантай холбоотой билээ. Үүнд:

Эдийн засгийн хучин зүйл: Зүүн Азийн эдийн засгийн хөгжлийн уялдаа буюу харилцан нөлөөлөл эртнээс эхлэлтэй бөгөөд хөгжлийн явцад бие биенээс нягт хамааралтай болж ирсэн нь яваандаа зохион байгуулалттай хамтын ажиллагаа, интеграцчилах үйл явц руу түлхэж эхэлсэн байна. Тухайлбал 90-ээд оны Зүүн Азийн санхүүгийн хямрал түүнийг хамгийн тод сануулсан билээ.

Түүнээс гадна орчин үеийн эдийн засгийн глобалчилал, улс орон, бүс нутгуудын эдийн засгийн эрчимтэй хөгжил, түүний өрсөлдөөнт шинж чанар Зүүн Азид эдийн засгийн олон талт хамтын ажиллагаа хөгжихөд гүнзгий нөлөөлсөн.

Аюулгүй байдлын хучин зүйл: Зүүн Өмнөд Азийн улсуудын

*С.Дашцэвэл - Доктор (Ph.D), дэд профессор

Холбоо (ASEAN)-ны орнуудын хаяа залгаа Өмнөд Хятадын тэнгис дэх тогтворгүй байдал ASEAN-ы орнуудын санааг зовоож эхэлсэн. Тухайлбал 90-ээд оны дундуур Тайваны улс төрийн байдлаас болж АНУ, Хятадын харилцаа хүйтэрч, тэнд тэнгисийн цэргийн баазууд нэмэгдсэнтэй зэрэгцэн Хятад болон ASEAN-ы зарим гишүүн орнуудын хооронд газар нутгийн маргаан ширүүссэн билээ. Үүнээс үүдэн ASEAN-ы орнууд өөрийн үүрэг ролийг бүс нутгийн төдийгүй Зүүн Азийн хэмжээнд нэмэгдүүлж аюулгүй байдлын асуудлаа олон талт хамтын ажиллагаагаар баталгаажуулах, Зүүн Азид тогтвортой аюулгүй олон улсын тогтолцоог бүрдүүлэхийг хичээв. Энэ үүднээс 1994 онд ASEAN-ы ARF хэмээх аюулгүйн асуудлаарх олон талт хамтын ажиллагааны үйл явц бий болсон байна.

Зүүн Азийн регионализмын талаарх анхны албан бус уулзалт 1997 оны сүүлчээр болсон бөгөөд үүнд ASEAN-ы 10 орон, Хятад, Япон, Солонгос оролцсон юм. Хамтын ажиллагааны шавыг тавьсан анхны энэ уулзалтаас хойш эдүгээ арван тав зургаан жил өнгөрчээ. Энэ хугацаанд Зүүн Азийн хамтын ажиллагаа багагүй ахицыг олж хамтын ажиллагааны олон талт механизмууд үүсч үйл ажиллагаагаа тогтмолжуулаад байна. Нэг зүйлийг анзаарахад үүний ихэнхийг ASEAN-ы талаас санаачилсан байдаг нь Зүүн Азийн олон талт хамтын ажиллагаан дахь ASEAN-ы үүрэг ролийг тодотгож байгаа бөгөөд энэхүү үйл явц ASEAN-ы аюулгүй байдал, эдийн засгийн эрх ашигтай илүү нягт холбоотойг илтгэж байгаа юм.

Зүүн Азид эдүгээ ASEAN, ASEAN+3, ASEAN+6, EAS (East Asian Summit буюу Зүүн Азийн Дээд уулзалт) гэсэн хэд хэдэн бүтэц бүхий нэгдсэн сүлжээ үйл ажиллагаагаа явуулж байна. Зүүн Азийн Дээд уулзалтыг Малайз улс анх санаачилсан бөгөөд анхны хуралдаан 2005 онд Куалалумпурт болжээ. Эхний үед Зүүн Азийн Дээд уулзалтыг Хятад, Малайзийн тал ASEAN+3 -ийн хүрээгээр "хязгаарлах" бодлоготой байсан бол Япон, Сингапурын хувьд өөр бусад орнуудын төлөөллийг хамруулах саналтай байв. Энэхүү санал зөрөлдөөнийг шийдвэрлэхдээ Зүүн Азийн Дээд уулзалтад оролцох орнуудын хувьд тусгай болзол шалгуур тогтоохоор шийджээ. Үүнд дараах 3 болзлыг хангасан байх. Үүнд:

- ASEAN -ы яриа хэлцээний түнш байх
- Бүсийн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцдог байх
- ASEAN -ы Найрамдал Хамтын ажиллагааны Гэрээнд (ТАС) нэгдсэн байх гэх мэт

Үүний дараахан эдгээр болзлыг хангасан Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг хожим нь АНУ, Орос Зүүн Азийн Дээд хэмжээний

уулзалт (EAS)-д нэгдэв. Гэвч Хятад тэргүүтэй “хязгаарлах” талынхны бодлого түлхээсээр өөр нэг санал баталгаажив. Тэр нь юу гэвэл Зүүн Азийн Хамтын Нийгэмлэг (East Asian Community)-ийг хэрэгжүүлэх зорилт бол зөвхөн ASEAN+3-ын орнуудад хамаарах бөгөөд EAS-ийн хувьд Зүүн Азийн Хамтын Нийгэмлэгт оролцох зорилгогүй гэсэн санааг зөвшөөрүүлсэн явдал юм. (Жич: Зүүн Азийн Хамтын Нийгэмлэг жинхэнэ биелэлээ олох нь 30, 40 жилийн дараах асуудал бөгөөд эхний гол зорилго нь Зүүн Азийн Чөлөөт худалдааны бүс (EAFTA)-ийг хэрэгжүүлэх явдал билээ).

Иймд одоохондоо EAS бол ASEAN-ы үндсэн зарчмуудыг баримталж үйл ажиллагаагаа явуулдаг, Зуун Азийн бус нутагт энх тайван тогтвортой байдлыг бий болгож эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэх зорилготой хөгжлийн стратеги, улс төр эдийн засгийн асуудлыг бус нутгийн эрх ашгийн үүднээс хэлэлцэн шийдвэр гаргадаг төр засгийн дээд удирдлагуудын албан ёсны индэр хэмээн тодорхойлж болох юм. EAS-ийн гүйцэтгэх үүрэг, эдийн засгийн хамтын ажиллагааны зорилт хэрхэн өргөжихийг цаашдын үйл ажиллагаа харуулах бизээ.

Зүүн Азийн Дээд Уулзалт жил тутам ASEAN-ы Дээд Уулзалт (Asean Summit)-ын дараа чуулдаг. 2005 оны анхны хуралдаанаас хойш жил тутам ASEAN-ы гишүүн орнуудад ээлж дараалан чуулж дараах асуудлыг хэлэлцжээ. Үүнд: Малайзид чуулсан нэгдүгээр хуралдаанаар Зүүн Азийн эрчим хүчний аюулгүй байдлыг хэлэлцэж хамтарсан мэдэгдэл гаргав. Дараагийн хуралдаанууд Филиппин, Сингапур, Тайландад болсон бөгөөд цаг уурын өөрчлөлт, байгаль орчны асуудлыг хэлэлцсэн боловч эдгээр хуралдаанаар ASEAN+3-ын чөлөөт худалдааны гэрээ, Зүүн Азийн хамтын Нийгэмлэг зэрэг асуудлыг ер хэлэлцсэнгүйн учир нь Хятад, Японы байр суурь өөр хоорондоо зөрүүтэй байсантай холбоотой байв. Хятад, Япон аль аль нь өөр өөрийн эрх ашгийг бодож асуудалд хандаж байсан бөгөөд тэр нь Зүүн Азийн Дээд уулзалтын хэлэлцэх асуудалд нөлөөлж байв. Хятад улс ASEAN+3-ын хүрээн дэх Чөлөөт худалдааны бүсийг бий болгох тухай онцлон анхаарч байхад Япон улс глобал эдийн засгийн стратегийнхаа хүрээнд “Зүүн Ази дахь эдийн засгийн өргөн түншлэл” /Comprehensive Economic Partnership for East Asia/-ийн үзэл санааг дэвшүүлж байв. Түүний гол үзэл санаа нь зөвхөн худалдаа төдийгүй хөрөнгө оруулалт, үйлчилгээ, хүний нөөц, оюуны өмчийн эрхийг хамгаалах зэрэг өргөн хүрээг хамарсан хамтын ажиллагааг эрхэмлэх явдал бөгөөд хамрах улс орнууд нь зөвхөн ASEAN+3-аар хязгаарлагдахгүй юм. Энэхүү санал зөрөлдөөний гол шалтгаан

нь хэрвээ ASEAN+3-ын хүрээнд чөлөөт худалдааны бус болон Зүүн Азийн хамтын нийгэмлэгийг бий болгох аваас Хятадын эдийн засгийн нөлөө давамгайлах талтай учир түүнийг тэнцвэржүүлэх арга нь Зүүн Ази дахь өргөн түншлэлийн арга хэмээн Япон зэрэг орнууд үзэж буйтай холбоотой юм. Үүнийг Хятадын зүгээс харахдаа Япон, АНУ, Австрали тэргүүтэй АНУ-ын нөлөө давамгайлсан Зүүн Азийн эдийн засгийн дэг журам бий болгох санаархал хэмээн үзэж буй ажээ. Энэхүү санал зөрөлдөөнтэй байдлыг харгалзан 2011 оны 11 сард чуулсан ASEAN-ы 19-р Дээд уулзалтаас өөр нэг санал дэвшин гарч ирэв. Тэр нь Regional Comprehensive Economic Partnership (RCEP) буюу Бүсийн эдийн засгийн өргөн түншлэлийг хэрэгжүүлэх санал юм. Бүсийн гэдэгт ASEAN-ы орнууд дээр Хятад, Япон, Солонгос, Энэтхэг, Австрали, Шинэ Зеландийг хамруулж байгаа бөгөөд эдгээр орнууд нь ASEAN-ы түнш орнууд юм. Өөрөөр хэлбэл Орос, АНУ-аас бусад EAS-ийн гишүүн орнууд үнд хамрагджээ.

RCEP-ийн гол агуулга нь дээр дурдсан 16 орон хамтран FTA буюу чөлөөт худалдааны бүсийг байгуулах явдал юм. Гэхдээ Зүүн Азийн 16 орон гэсэн нэр томъёог энд хэрэглэхгүй ASEAN+6 гэсэн томъёог хэрэглэж байгаа нь ASEAN төвтэй байх, өөрөөр хэлбэл ASEAN-ы удирдах ролийг хадгалах гэсэн бодлоготой холбоотой юм.

Энэ санал эдүгээ бүрэн шийдэлд хүрч ASEAN+6-ийн чөлөөт худалдааны бус байгуулах үйл явцыг эхлүүлээд байна. Үүнд тус чөлөөт худалдааны бүсийг байгуулах ажлын багийг 2013 оны эхээр байгуулж бүтээгдэхүүний гарал үүслийн дүрэм журмын асуудлуудыг судалж, гааль татварын хэмжээ, гишүүн улс бүрийн худалдааны давуу эрхийн журам зэргийг тодорхойлж байна. Үүний дараа бараа, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын асуудлыг судлах ажлын багийг ажиллуулж 2015 он гэхэд RCEP-ийн гэрээ хэлцлийг дуусгахаар тооцоолж байна. Ийнхүү ASEAN+6-ийн чөлөөт худалдааны бүсийг бий болгохдоо ASEAN+1-ийн (ASEAN+Хятад, ASEAN+Солонгос, ASEAN+Япон, ASEAN+Энэтхэг, ASEAN+Австрали-Шинэ Зеланд) чөлөөт худалдааны гэрээнд хуримтлуулсан туршлагад тулгуурлаж түүний сул талыг гэтлэн давж худалдаа, хөрөнгө оруулалтын нэгдсэн журмыг бий болгон чөлөөт худалдааны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, гааль татварын хөнгөлөлтийг илүү өндөр түвшинд хүргэх ажээ. Тэхдээ хөгжлийн түвшин харилцан адилгүй ASEAN-ы гишүүн орнуудын эрх ашигт илүү нийцсэн гэрээний нэгдсэн хувилбарыг сонгох ажээ.

Одоо энэхүү ASEAN+6-ийн чөлөөт худалдааны бүсийг бий болгох асуудал ASEAN, ASEAN+3, Зүүн Азийн Дээд уулзалтуудын

гол сэдвийн нэг болоод байна.

Өнгөрсөн жилүүдэд бүс нутгийн хамтын ажиллагаанд нэгдэх гэсэн манай улсын эрмэлзлэл нэн тодорхой бөгөөд зарим нэг үр дүнд хүрчээ. Тухайлбал:

- 1990-ээд оноос Зүүн Хойт Азийн “Түмэн голын” төсөлд оролцож ирсэн.

- 1991 онд Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны Зөвлөл буюу ПЕКК-д элсэн орох хүсэлтээ гарган Үндэсний хороог байгуулж 2001 онд түүний гишүүн болсон

- 1998 онд ASEAN-ы Бүсийн Чуулга (ASEAN Regional Forum-ARF)-д элсч түүний төрөл бүрийн түвшний үйл ажиллагаанд тогтмол оролцож ирсэн

- 2004 онд Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээ (Asian Cooperation Dialogue - ACD)-нд нэгдэн орсон.

- 2005 онд ASEAN-ы Найрамдал хамтын ажиллагааны Гэрээ (Treaty of Amity and Cooperation- TAC)-нд нэгдэн орсон гэх мэт.

Энэ нь Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын чиглэлийн дагуух зүй ёсны үйл ажиллагаа бөгөөд дэлхий дахины өнөөгийн хөгжлийн онцлог, манай орны хөгжлийн ирээдүйтэй холбоотой нэн чухал асуудлаас урган гарсан зорилт гэдэг нь хэн бүхэнд тодорхой.

Манай улс Зүүн Азийн Дээд хэмжээний уулзалтанд оролцох хүсэлтээ Малайз, Вьетнамаар дамжуулан 2006, 2010 онуудад тавьсан ажээ. Гэвч ASEAN-ы яриа хэлцээний тунш орон байх ёстой” гэсэн болзол тулгардаг. ASEAN-ы “яриа хэлцээний тунш” орон гэдэг нь ASEAN-тай эдийн засаг улс төрийн өргөн харилцаатай орнууд билээ. Тухайлбал АНУ, Европын Холбоо, Хятад, Орос, Япон, Энэтхэг, Солонгос, Австрали, Шинэ Зеланд, Тайвань ASEAN-ы яриа хэлцээний тунш гэгддэг.

Сүүлийн үед Монгол улсын эдийн засгийн өсөлт тогтвортой бөгөөд өндөр байгаагаас гадна уул уурхайн шинэ шинэ орд нээгдэж дэлхийн томоохон улс орнуудын анхаарлыг татаж эхлээд байгаа хэдий ч аж үйлдвэрийн боловсруулах салбар сул хөгжиж нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ хязгаарлагдмал зэрэг шалтгаанаас үүдэн ASEAN-ы гишүүн орнуудтай худалдаа, эдийн засгийн өргөн харилцаа хараахан бүрэлдээгүй байгаа тул тэр яриа хэлцээний туншийн эгнээнд орж чадахгүй байгаа юм.

Зүүн Азид өрнөж байгаа олон талт хамтын ажиллагааны үйл явцаас харахад эдүгээ ASEAN+3-аас илүү ASEAN+6-ийн эдийн

засгийн интеграци идэвхижих хандлагатай байна.

ASEAN, ASEAN+6, EAS зэрэг Зүүн Азийн хамтын ажиллагааны аль ч бүтцэд нэгдэхэд гол нөхцөл нь ASEAN-ы *яриа хэлцээний түнш* болох явдал билээ.

Иймд Зүүн Азийн хамтын ажиллагааны бүтцүүдэд нэгдэн орохын тулд бид юу хийх шаардлагатай вэ?

а/ Юуны өмнө *үндэсний аж үйлдвэрийг оновчтой хөгжүүлж* нэмүү өртөг шингэсэн өрсөлдөх чадвартай экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах явдал хамгийн чухал гэдэг нь эндээс харагдана. Манай улс түүхий эд гололсон экспортод найдаж интеграцид нэгдэх нь нэн эрсдэлтэй тул экспортод чиглэсэн эцсийн бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулахад илүү анхаарч цаг хугацааг товчлох нь туйлын чухал болоод байна.

б/ Одооноос Зүүн Азийн хамтын ажиллагааны бүтцүүдэд ялангуяа ASEAN-ы яриа хэлцээний түншийн түвшинд хэзээ хүрэх, Зүүн Азийн Дээд хэмжээний уулзалт, ASEAN-6-д хэзээ хэрхэн оролцох талаар Засгийн Газрын стратегийг боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг цаг хугацаагаар эрэмбэлэн төлөвлөх нь зүйд нийцэх мэт.

в/ Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс (EAFTA)-ийг байгуулахдаа юуны өмнө Зүүн Азийн орнуудын хоёр талын чөлөөт худалдааны гэрээ, ASEAN+6 -ийн чөлөөт худалдааны гэрээ гэсэн хэлбэрээр дамжин бүрэлдэх төлөв буй болж байна. Тэгэхлээр бид Зүүн Азийн аль нэг оронтой хоёр талын чөлөөт худалдааны гэрээ байгуулах замаар эхлэх нь зүйтэй мэт. Гэхдээ хил залгаа биш оронтой бол эдийн засгийн аюулгүй байдал талаасаа илүү ашигтай. Манай улс Япон улстай энэ талын яриа хэлцэл эхлээд байгаа нь сайшаалтай. Улс орны эдийн засгийн чадавхи, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний чанар, тоо хэмжээ нэмэгдэхийн хэрээр Зүүн Азийн бусад улстай энэ талын гэрээ хэлцлийг өргөжүүлэх нь дамжиггүй билээ.

г/ Зүүн Азийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд чиглэгдсэн зарим албан бус сувагт оролцох боломжийг судлах хэрэгтэй байна. Эдүгээ Зүүн Азийн орнуудын гол шинжээч мэргэжилтнүүдийн мэтгэлцээний талбар болсон албан бус сувгийн ач холбогдол нэн их. Зүүн Азийн хамтын ажиллагааны цаашдын зорилтыг тодорхойлох, хамтын ажиллагааны явцад тохиоллож буй зарим бэрхшээлийг даван туулахад гишүүн орнуудын байр суурийг ойртуулах гэх мэт нэн тулгам асуудлыг шийдэхэд үйл ажиллагаа нь чиглэгддэг эдгээр сувгуудаас гарсан санал санаачлагууд ASEAN, ASEAN+3, ASEAN+6, EAS-ийн шийдвэрт чухал нөлөөтэй.

Иймд Зүүн Азийн зарим 2-р сувгийн үйл ажиллагаанд оролцож чадвал Зүүн Азийн интеграцийн явцыг ойрын зайнаас тандан судалж дотор зуурын нарийн ширийн асуудлын талаарх мэдээллийг өөрийн орны бодлого тодорхойлогчдод шуурхай хүргэхээс гадна бодлогын чанартай зөвлөмж өгөх боломж илүү олох юм. Ер Зүүн Азийн олон талт хамтын ажиллагаанд оролцох боломж, ач холбогдол хийгээд тулгарах бэрхшээл сорилтыг бодитойгоор урьдчилан харж бэлтгэлийг хангахад албан бус сувгийн оролцоо нэн ач холбогдолтой. Миний бодлоор Зүүн Азийн бүс нутгийг, түүний эдийн засаг, улс төрийн хамтын ажиллагааг, ялангуяа Зүүн Азид эдийн засгийн өргөн түншлэлийг болон ASEAN+6 -ийн чөлөөт худалдааны бүсийг хэрхэн байгуулах талаар санал бодлоо түлхүү солилцдог 2-р сувгийн үйл ажиллагаанд оролцохыг эрмэлзэх. Үүний тул энэ сувагт хэрхэн оролцож болох талаар сувгийг санаачлагч талуудын зөвлөлгөөг авах нь зүйтэй болов уу. (Албан бус 2-р сувгуудын тухай 7-р зүүлтээс харна уу)

д/. ASEAN-ы Найрамдал Хамтын Ажиллагааны Гэрээн(ТАС)-д нэгдэн орсон давуу талаа ашиглан ASEAN-ы орнуудын хэрэгжүүлж буй зарим төсөл, хамтын ажиллагаанд санаачлагатай оролцохыг эрмэлзэх нь Зүүн Азийн интеграцид нэгдэх Монгол улсын бодлогод чухал алхам болох нь маргаангүй.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. *Nhũng xu the phat trien cua the gioi va khu vuc giai doan 2001-2015* (2001-2015 оны дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн хандлага). *Sac giai phap phat trien quan he Nga-ASEAN trong boi canh quoc te moi*. Ha Noi, 2009.

2. *Huong toi cong dong kinh te Dong A*(Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийг буй болгох нь). Ha Noi, 2004.

3. *Lien ket ASEAN trong thap nien dau the ky XXI* (21-р зууны эхний арван жил дэх ASEAN-ы эдийн засгийн хамтын ажиллагаа). Ha Noi, 2006.

4. *Dong Bac A: Nhung van de kinh te noi bat*(Зүүн Хойт Ази: Эдийн засгийн зарим асуудал). Ha Noi, 2011.

5. *Su hinh thanh Hiep dinh doi tac kinh te toan dien khu vuc* (Бүс нутгийн эдийн засгийн өргөн түншлэл буй болж байгаа нь). *Nghien cứu Đông Nam Á*, 3/2013. Tr. 15-22.

6. *Kenh doi thoai khong chinh thuc ve an ninh va chinh tri - Kenh 2 cua ASEAN*. (Улс төр аюулгүй байдлын албан бус сувгууд ASEAN-ы 2-р сувгууд). Ha Noi , 2010. Энэ бүтээлд дурдсан

Зүүн Азийн хамтын ажиллагааны үйл явцад туслах 2-р сувгийн заримаас танилцуулахад: а/ASEAN-ы гишүүн орнуудын судалгааны хүрээлэнгүүдийн мэргэжилтэн судлаачид, зарим дээд тушаалын хүмүүс оролцож бүс нутгийн улс төр аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн тулгам асуудлыг хэлэлцдэг 2-р суваг-ASEAN Institute of Strategic and International Studies (ASEAN-ISIS). Анх 1988 онд байгуулагдсан энэ сувгийн санал санаачлагаар ARF, AFTA бий болсон. Энэ сувагт оролцогч орнууд харин татвар төлдөг. б/ ASEAN+3-ын хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцдэг 2—р суваг East Asian Congress (EAC), East Asian Forum (EAF), Network East Asian Think-tank (NEAT), Network East Asian Studies (NEAS). Зүүн Азийн Их хурал (EAC) нь 2003 онд Малайз улсын саналаар байгуулагдсан бөгөөд Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үүнд санхүүгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт худалдааны хамтын ажиллагаа руу түлхүү анхаардаг бол Зүүн Азийн Чуулга (EAF) нь эдийн засгаас гадна улс төр аюулгүйн асуудал голлон хэлэлцдэг байна. Энэ хоёр сувгийн үйл ажиллагаа бараг үеэ өнгөрөөсөн гэж үзэж болно. Харин 2004 онд байгуулагдсан “Зүүн Азийн Шинжээчдийн багийн Сүлжээ”(NEAT) нь Зүүн Азийн Хамтын нийгэмлэгийг, ялангуяа Зүүн Азийн Чөлөөт худалдааны бүс (EAFTA)-ийг хэрхэн бий болгох талаар санал боловсруулахад чиглэгджээ. Хожим байгуулагдсан “Зүүн Ази судлалын Сүлжээ (NEAS) - ний хувьд бүс нутаг дахь Зүүн Ази судлалын хүрээлэн, Их Дээд сургуулиудын судалгааны ажлыг нэгтгэн зангидсан шинж чанартай сүлжээ тул гол нь Зүүн Азийг бүс нутгий нь хувьд гүнзгийрүүлэн судалж олон нийтэд ойлгуулах зорилготой байгуулагдсан ажээ. Эдгээр II сувгууд жил тутам хуралдаж өөрийн санал зөвлөмжийг ASEAN+3-ын Ерөнхий хороонд өгч тэндээс эцсийн шийдэл гардаг. Тэдний санал зөвлөмж нь Зүүн Азийн Хамтын Нийгэмлэг (East Asian Community) -ийг бий болгох хөтөлбөрт тусгалаа олдог. с/ EAS-ийн эдийн засгийн асуудлыг судалдаг Economic Research Institute for (Asean and Asia) буюу ERIA нь 2007 онд Зүүн Азийн эдийн засгийн өргөн түншлэлийг судлах гол суваг болж түүний илтгэлийг EAS-ийн дараа дараачийн уулзалтаар сонсч хэлэлцдэг болжээ. Бидний анхаарлыг татах гол суваг энэ байж магад.

7. Phan ung chinh sach cua ASEAN truoc su bien dong dia chinh tri Dong A trong thap nien dau the ky XXI (21-р зууны эхэн дэх Зүүн Азийн геополитик ба ACEAN-ы бодлого). Nghien cuu Dong Nam A, 4/2010. Tr.27-34.

Abstract:

In the last years the regional integration process has been developed intensively in the East Asia with the influences of such factors as, the rapid growth of global economy and its competition, regional economic and political security in the globalization era. Mongolia is located in this region, and trying to participate in these regionalization processes. It is not possible for us to join East Asian structures, including ASEAN, ASEAN+3, ASEAN+6 and EAS yet, because our country is not a dialogue partner of ASEAN. Therefore, the dialogue partnership with ASEAN is the first vision for our country. In order to achieve it we will actively participate in the market of ASEAN countries and expand the economic cooperation. The step to expand the economic cooperation is the fast industrialization in our country. Our main strategy will be: 1/Formulate the government strategy for joining to ASEAN and East Asian integration and plan the program of action for implementing it from present days step by step. The basic content of this program should be the work to industrialize urgently and precisely (correctly) 2/ Study the possibility to participate in several informal dialogue canals (Canal II) of East Asian Cooperation with the purpose for observing the integration processes of East Asia and introduce our country policies and share the ideas; 3/Try to participate in some projects and cooperation implemented by ASEAN countries, initiatively using our advantages which have been jointed the Treaty of Amity and Cooperation.